

ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ГАЗРЫН ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН БИЕЛЭЛТ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН
ГАНТУЛГЫН ГЭРЭЛТУЯАГИЙН 2025 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин					Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)				
1	2	3	4	5	6			7	8
Зорилт 1. Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Засгийн газрын тогтоол, шийдвэр, үндэсний хөтөлбөр, Хууль зүй, дотоод хэргийн сайдын болон бусад яамдын сайд нарын баталсан шийдвэр, үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангуулах, биелэлт, мэдээ тайланг нэгтгэх, тайлагнах									
1.	Арга хэмжээ 1.1. Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Засгийн газрын тогтоол шийдвэрийн нэгдсэн мэдээ тайланг холбогдох байгууллагад хүргүүлэх	Тайлан бэлтгэж хүргүүлсэн гүйцэтгэлийн хувь	100%	50%	Монгол Улсын Ерөнхий сайдын 2024 оны 71 дүгээр захирамжаар баталсан “Эрэгтэй, эмэгтэй хүний дундаж наслалтын зөрүүг багасгах /2024-2027/)” төлөвлөгөөний хэрэгжилтийг 12 дугаар сарын 06-ны өдрийн 02/2446 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн. Монгол Улсын Ерөнхий сайдын “Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлагдсантай холбогдуулан 2024 онд багтаан хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний тухай” 2024 оны 01 дүгээр албан даалгаврын хэрэгжилтийг 12 дугаар сарын 09-ний өдрийн 01/2466 дугаар, “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлого, Шинэ сэргэлтийн бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай 2024 оны 02 дугаар албан даалгаврын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийг 02 дугаар сарын 13-ны өдөр, “Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай” 2025 оны 02 дугаар албан даалгаврын хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг 03 дугаар сарын 25-ны өдрийн 01/622 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд тус тус хүргүүлсэн. Монгол Улсын Ерөнхий сайдын 2024 оны “Тогтоолын хэрэгжилтийг хангуулах тухай” 03 дугаар албан даалгаврын хүрээнд Цахим хөгжил, инновац, харилцаа			01-06	

1	2	3	4	5	6	7	8
					холбооны сайдаас ирүүлсэн чиглэлийн дагуу “Мэдээллийн технологийн судалгаа”-д хамрагдсан мэдээллийг 01 дүгээр сарын 31-ний өдрийн 02/271 дүгээр албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлээ. Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас яамдын Төрийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын агентлаг, Шадар сайдын ажлын албаны удирдлагад хүргүүлсэн чиглэлийн дагуу авсан арга хэмжээний биелэлтийг 12 дугаар сарын 11-ний өдрийн 01/2476 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлээ. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2024 он 73 дугаар зарлигаар батлагдсан “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг мэдээллээр хангах журам”-ын дагуу холбогдох хэсгийн 2024 оны 4 дүгээр улирал, 2025 оны 1 дүгээр улирлын танилцуулах мэдээг 12 дугаар сарын 13-ны өдрийн 01/2496 дугаар, 03 дугаар сарын 26-ны өдрийн 01/631 дүгээр албан бичгээр тус тус Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлэв. Байгууллагын үйл ажиллагаанд хамаарах стандартын хэрэгжилтийн тайлан 2023-2025 оны мэдээллийг 05 дугаар сарын 07-ны өдрийн 01/903 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.		
2.	Арга хэмжээ 1.2. Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн нэгдсэн тайланг холбогдох газарт хүргүүлэх	Тайлан бэлтгэж, хүргүүлсэн гүйцэтгэлийн хувь	100%	50%	Монгол Улсын хууль тогтоомжийн 2024 оны тайланг 12 дугаар сарын 17, 23-ны өдөр, 2025 оны 01 дүгээр сарын тайланг 02 дугаар сарын 04-ний өдөр тус тус _____ 1 цахим хаягаар Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн. “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2024 оны тайланг 12 дугаар сарын 02-ны өдөр _____ 1 цахим хаягаар, мөн Монгол Улсыг 2020-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн	01-06	

1	2	3	4	5	6	7	8
					чиглэлийн 2024 оны тайланг 12 дугаар сарын 23-ны өдрийн 01/2563 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүллээ. “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын тайланд үнэлгээ хийж байгаатай холбогдуулан үр дүнгийн тайланг 04 дүгээр сарын 18-ны өдрийн 01/773 дугаар албан бичгээр болон _____ цахим шуудангаар Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн. Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 2024 оны тайланд нотломж, нэмэлт мэдээллийг 01 дүгээр сарын 22, 02 дугаар сарын 13-ны өдөр тус тус Хууль зүй, дотоод хэргийн яаманд цахимаар хүргүүлсэн. Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт туссан зорилтын хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний 2024 оны тайланг 01 дүгээр сарын 23-ны өдрийн 01/200 дугаар албан бичгээр болон _____ цахим хаягаар Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүллээ. Монгол Улсын хууль тогтоомж, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1 дүгээр улирлын тайланг 04 дүгээр сарын 04-ний өдрийн 01/679 дүгээр албан бичгээр болон _____ цахим шуудангаар тус тус Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.		
3.	Арга хэмжээ 1.3. Дээд шатны байгууллагаас ирүүлсэн байгууллагын үйл ажиллагаанд хамаарах хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг бүртгэж	Хяналтад авсан тогтоол, шийдвэрийн тоо	9	Тухай бүр ирүүлсэн тоо	Монгол Улсын хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн байгууллагад хамаарах 171 баримт бичгийн 561 арга хэмжээний жагсаалтыг эрх зүйн мэдээллийн нэгдсэн системээс шүүлт хийж, 2025 оны байдлаар шинэчлэн egr.e-mongolia.mn системд төв болон хилийн боомт, орон нутаг дахь хэсэгт нийтэлж, албан хаагчдад танилцуулж, холбогдох зөвлөмж, чиглэлийг өгч ажилласан.	01-06	

1	2	3	4	5	6	7	8
	хяналтад авах				Тайлант хугацаанд дээд шатны байгууллагаас Засгийн газрын тогтоол 2, Ерөнхий сайдын албан даалгавар 2 буюу нийт 4 баримт бичиг ирүүлснийг хяналтад нэмж, ер.e-mongolia.mn системээр албан хаагчдад танилцуулан хэрэгжилтийг хангуулж тайлагналаа.		
4.	Арга хэмжээ 1.4. Дээд шатны байгууллагын тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг нэгтгэн тайлагнаж, хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан нэгжид хүргүүлэх	Тайлан бэлтгэж, хүргүүлсэн гүйцэтгэлийн хувь	100%	50%	Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан журмын дагуу хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 01 дүгээр сарын тайланг боловсруулж, 02 дугаар сарын 04-ний өдөр Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт үнэлгээ хийлгэхээр хүргүүлсэн. “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2024 оны тайланг тус тус боловсруулж, 12 дугаар сарын 02-ны өдөр тус тус Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт үнэлгээ хийлгэхээр хүргүүлээ. Монгол Улсын хууль тогтоомж, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1 дүгээр улирлын тайланг тус тус үнэлгээ хийлгэхээр 04 дүгээр сарын 04-ний өдөр хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан нэгжид илгээсэн. Алсын хараа-2050” бодлогын баримт бичгийн хэрэгжилт, үр дүнгийн эмхэтгэлд зориулан виз, оршин суух зөвшөөрлийн мэргэжилтнээс албан хаагчийн ярилцлагыг авч, боловсруулан 04 дүгээр сарын 29-ний өдөр хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудит хариуцсан нэгжид хүргүүлэв.	01-06	
5.	Арга хэмжээ 1.5. Хууль зүй, дотоод хэргийн болон бусад яамдаас ирүүлсэн шийдвэрийн	Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо, үр дүн	4	Тухай бүр ирүүлсэн тоо	“НҮБ-ын хүний эрхийн зөвлөлөөс гаргасан зөвлөмжүүдийг 2023-2025 онд хэрэгжүүлэх арга хэмжээний ерөнхий төлөвлөгөөний 2024 оны хэрэгжилтийг 12 дугаар сарын 19-ний өдрийн 01/2547	01-06	

1	2	3	4	5	6	7	8
	хэрэгжилтийг хангуулж, биелэлтийг нэгтгэн тайлагнах				дугаар албан бичгээр Гадаад харилцааны яаманд хүргүүлсэн. “Бизнесийн үйл ажиллагаанд хүний эрхийг хамгаалах, хүний эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, зөрчигдсөн эрхийг сэргээх үйл ажиллагааны төлөвлөгөө (2023-2027)”-ний 2023, 2024 оны хэрэгжилтийг нэгтгэн боловсруулж, 02 дугаар сарын 05-ны өдрийн 01/302 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүллээ. Монгол Улсад хувийн хэргээр оршин суух гадаадын иргэдийн 2020-2024 оны тоон мэдээ болон цагаачлан оршин суух гадаадын иргэдийн 2022-2024 оны тоон мэдээг 01 дүгээр сарын 15-ны өдрийн 01/104 дүгээр албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.		
6.	Арга хэмжээ 1.6. Хууль зүй, дотоод хэргийн сайдын шуурхай хурлаас гарсан үүрэг даалгаврын хэрэгжилтэд хяналт тавьж, гүйцэтгэлийг тайлагнах	Биелэлт бэлтгэж, хүргүүлсэн гүйцэтгэлийн хувь	100%	50%	Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн шуурхай хуралдаанаар өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх төлөвлөгөөг 01 дүгээр сарын 07-ны өдөр байгууллагын даргаар батлуулж, egr.e-mongolia.mn системээр нийт албан хаагчдад танилцуулан биелэлтийг хангуулж, тайланг 02 дугаар сарын 20-ны өдөр удирдлагад танилцууллаа. Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн шуурхай хуралдаанаар өгсөн үүрэг даалгаврын хүрээнд төрийн албан хаагчид болон олон нийтэд хууль тогтоомж сурталчлах ажлын 2025 оны төлөвлөгөөнд саналыг 01 дүгээр сарын 07-ны өдрийн 02/34 дүгээр албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн. Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн шуурхай хуралдаанаас өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг 04 дүгээр сарын 07-ны өдрийн 01/700 дугаар албан бичгээр болон цахим хаягаар Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүллээ.	01-06	

1	2	3	4	5	6	7	8
					Тайлант хугацаанд сайдын шуурхай хуралдаан дахин хуралдаагүй болно.		
Зорилт 2. Дээд шатны байгууллагаас гаргах тогтоол шийдвэр, хууль эрх зүйн чиглэлээс бусад баримт бичигт байгууллагаас тусгах саналыг боловсруулах, хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх							
7.	Арга хэмжээ 2.1. "Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө"-ний төсөлд санал боловсруулж дээд шатны байгууллагад хүргүүлэх арга хэмжээг зохион байгуулах	Төслийн санал боловсруулж, хүргүүлсэн тоо	1	1	"Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө"-ний төсөл боловсруулах ажлын хэсгийг байгууллагын даргын 2024 оны А/524 дүгээр тушаалаар байгуулсан. Ажлын хэсэгт нарийн бичгийн даргаар ажиллаж, нэгжүүдээс саналыг нэгтгэн Эдийн засаг, хөгжлийн сайдын 2022 оны А/167 дугаар тушаалаар батлагдсан "Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө боловсруулах аргачлал"-ын дагуу боловсруулж, 01 дүгээр сарын 10-ны өдрийн 01/70 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэлд хүргүүлсэн. "Монгол Улсын хөгжлийн 2026 оны баримтлах бодлого, тэргүүлэх чиглэл"-ийн төсөлд саналыг боловсруулан 03 дугаар сарын 11, 17-ны өдрүүдэд Хууль зүй, дотоод хэргийн яаманд цахим хаягаар хүргүүлээ. "Монгол Улсын хөгжлийн 2026 оны баримтлах бодлого, тэргүүлэх чиглэл" болон "Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө"-ний Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр Эдийн засаг, хөгжлийн яамнаас эцэслэсэн төсөлд саналыг 04 дүгээр сарын 17-ны өдөр Хууль зүй, дотоод хэргийн яаманд цахимаар хаягт хүргүүлсэн.	01-06	
8.	Арга хэмжээ 2.2. Улсын Их Хурал, Ерөнхий сайд, Шадар сайд, Засгийн газрын гишүүдээс батлах цаг үеийн шинжтэй хөтөлбөр, төлөвлөгөө болон бусад баримт бичигт санал боловсруулж,	Ирүүлсэн чиглэлд санал боловсруулж хүргүүлсэн гүйцэтгэлийн хувь	100%	50%	Төрөөс хүн, хуулийн этгээдэд үзүүлж байгаа үйлчилгээний судалгааг 12 дугаар сарын 04-ний өдрийн 02/2396 дугаар, Салбарын эрх зүйн шинэтгэл, сурталчилгааны мэдээллийг 12 дугаар сарын 05-ны өдрийн 02/2431 дүгээр албан бичгээр тус тус Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн. Монгол Улсын Засгийн газрын 2025 оны нэгдүгээр улирлын хуралдаанаар хэлэлцүүлэх асуудал болон Засгийн газрын хоёрдугаар 100 хоногт хэрэгжүүлэх	01-06	

1	2	3	4	5	6	7	8
	холбогдох байгууллагад хүргүүлэх				ажлын төлөвлөгөөнд саналыг 01 дүгээр сарын 02-ны өдрийн 01/08 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн. Шинжлэх ухаан, технологийн сангийн хөрөнгөөр 2025 онд санхүүжүүлэх захиалгат төсөл, арга хэмжээний саналыг 01 дүгээр сарын 31-ний өдрийн 01/272 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлж, танилцуулгыг бэлтгэн 04 дүгээр сарын 17-ны өдөр хуралдаанд оруулсан. “Бизнесийн үйл ажиллагаанд хүний эрхийг хамгаалах, хүний эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, зөрчигдсөн эрхийг сэргээх үйл ажиллагааны төлөвлөгөө (2023-2027)”-ний холбогдох зорилтуудын хүрээнд 2025 онд Хүний эрхийн Үндэсний Комисстой хамтран хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг 02 дугаар сарын 05-ны өдрийн 01/302 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн. Хууль зүй, дотоод хэргийн салбарын төрийн байгууллагуудын үйл ажиллагаанд хиймэл оюун ухаан ашиглах, өндөр технологи нэвтрүүлэх замаар бүтээмжийг нэмэгдүүлэх 2025 оны төлөвлөгөөнд саналыг нэгтгэн боловсруулж, 02 дугаар сарын 13-ны өдрийн 02/367 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлэв. Бүс, орон нутгийн түвшинд хэрэгжүүлэх мега төсөлд саналыг 03 дугаар сарын 28-ны өдрийн 01/635 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүллээ.		
9.	Арга хэмжээ 2.3. Байгууллагын үйл ажиллагааны сарын тайлангийн тоон мэдээг нэгтгэн хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан нэгжид хүргүүлэх	Хүргүүлсэн мэдээний тоо	12	6	Байгууллагын 2024 оны 11, 12 дугаар сар, 2025 оны 01, 02, 03, 04, 05 дугаар сарын үйл ажиллагааны тайлангийн тоон мэдээг холбогдох журмын дагуу боловсруулж, хүснэгт хэлбэрээр 12 дугаар сарын 09-ний өдөр 01 дүгээр сарын 06-ны өдөр, 02 дугаар сарын 06-ны өдөр, 03 дугаар сарын 10-ны өдөр, 04 дүгээр сарын 04-ний өдөр, 05 дугаар сарын 05-ны өдөр, 06 дугаар сарын 04-ний өдрүүдэд тус тус Хяналт-	01-06	

1	2	3	4	5	6	7	8
					шинжилгээ, үнэлгээ, аудитын хэлтэст хүргүүлэн баталгаажуулж, байгууллагын цахим хуудсанд нээлттэй мэдээлсэн.		
10.	Арга хэмжээ 2.4. Бодлогын баримт бичгийн тайланг байгууллагын цахим хуудаст нээлттэй байршуулах	Тайлангийн тоо; Байршуулсан тоо	5/5	2/2	“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2024 оны тайланг үнэлгээний хамт тус тус 12 дугаар сарын 25-ны өдөр байгууллагын цахим хуудаст нээлттэй мэдээллээ. Монгол Улсын хууль тогтоомж болон “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2025 оны 1 дүгээр улирлын тайланг үнэлгээний хамт тус тус 04 дүгээр сарын 10-ны өдөр байгууллагын цахим хуудаст нээлттэй мэдээлсэн. Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой мэдээ мэдээллийг олон нийтийн сүлжээнд 107 удаагийн түгээлт хийсэн байна.	01-06	

Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт

Д/д	Үүрэг даалгавар (арга хэмжээ)	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэл тийн хувь
1	2	3	4	5
1.	Арга хэмжээ 1. Зохион байгуулалтын нэгжийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулах (орлон ажилласан)	Тайлан, төлөвлөгөө хариуцсан ахлах мэргэжилтний ээлжийн амралтын хугацаанд орлон ажиллаж, төв болон хилийн боомт, орон нутаг дахь 16 нэгжийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг хянан байгууллагын даргаар батлуулж, буцаан хүргүүлэх ажлыг 01 дүгээр сарын 20-оос 23-ны өдрүүдэд зохион байгууллаа.	01-01	

1	2	3	4	5
2.	Арга хэмжээ 2. Захиргаа, удирдлагын газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт боловсруулах (ажил хэсэгчлэн түр орлосон)	Захиргаа, удирдлагын газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 1 дүгээр улирлын биелэлтийг албан хаагчдаас нэгтгэн боловсруулж 04 дүгээр сарын 03-ны өдөр Хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудитын хэлтэст хүргүүлсэн.	03-04	
3.	Арга хэмжээ 3. Нээлттэй өгөгдөл боловсруулж, системд мэдээлэх	Засгийн газрын 2024 оны 96 дугаар тогтоолын дагуу мэдээлэл хариуцагчийн сар бүр нийтлэх 11 төрлийн өгөгдлийг 2024 оны 11, 12 дугаар сарын байдлаар XLSX, CSV, JSON өргөтгөлөөр тус тус боловсруулж, 2024 он 12 дугаар сарын 16-ны өдөр, 01 дүгээр сарын 15-ны өдөр байгууллагын цахим хуудас болон Төрийн нээлттэй өгөгдлийн нэгдсэн систем (opendata.gov.mn)-д төлөвлөгөөнд тусгасан хугацаанд нийтэлсэн.	01-01	
4.	Арга хэмжээ 4. Танилцуулга боловсруулж, холбогдох нэгжид хүргүүлэх	Старлинк төхөөрөмжийн хэрэгцээ шаардлагын танилцуулгыг боловсруулж, 12 дугаар сарын 23-ны өдрийн 01/2561 дүгээр албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлэв. Цахим виз, гадаадын иргэний бүртгэл, хяналтын тогтолцооны танилцуулгыг тайлан, төлөвлөгөө хариуцсан ахлах мэргэжилтэн, олон нийттэй харилцах ахлах мэргэжилтэнтэй хамтран боловсруулж, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Гадаад харилцааны яаманд 03 дугаар сарын 14-ний өдрийн 01/541, 01/543 дугаар албан бичгээр тус тус хүргүүллээ. Богино хугацаатай, ажил хэргийн, уригчгүй визийг цахимаар олгох, зарим ангиллын цахим виз олгох улсын жагсаалт батлуулах тухай танилцуулгыг хянаж, Виз зөвшөөрлийн газарт 04 дүгээр сарын 02-ны өдөр хүргүүлсэн. Хууль зүй, дотоод хэргийн яамнаас эмхэтгэн гаргаж буй “Алсын хараа-2050” бодлогын баримт бичгийн хэрэгжилт, үр дүнгийн товхимолд “Цахим виз, гадаадын иргэний 48 цагийн бүртгэл” сэдвээр танилцуулга ярилцлага бэлтгэж 05 дугаар сарын 02-ны өдөр Хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудитын хэлтэст хүргүүлсэн.	01-05	
5.	Арга хэмжээ 5. Байгууллагын долоо хоногт хэрэгжүүлэх онцлох арга хэмжээний төлөвлөгөө, түүний хэрэгжилтийг Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлэх	Хууль зүй, дотоод хэргийн яамны онцлох үйл ажиллагааны төлөвлөгөөнд байгууллагад тухайн долоо хоногт зохион байгуулахаар төлөвлөсөн болон өмнөх долоо хоногт хэрэгжүүлсэн арга хэмжээний мэдээллийг тухай бүр буюу нийт 10 удаа хүргүүлж ажиллалаа.	03-06	
6	Арга хэмжээ 6. Чиглүүлэх сургалтад хичээл заах	Байгууллагын даргын 03 дугаар сарын 20-ны өдрийн 01-02/16 дугаар удирдамжаар шинээр томилогдсон албан хаагчдад “Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүд” сэдвээр хичээл заав.	03-03	

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
1.	Арга хэмжээ 1. Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад хамрагдах	Сертификатын огноо, дугаар	0	1	Төрийн албан хаагчид зориулсан “Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалт”-д Удирдлагын академид суралцаж 01 дүгээр сарын 17-ны өдрийн А5032 дугаар (бүртгэлийн дугаар 250197) гэрчилгээтэй дүүргэсэн.	01-01	
2.	Арга хэмжээ 2. Худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтан бэлтгэх (А3) сургалтад хамрагдах	Сертификатын огноо, дугаар	0	1	Төрийн худалдан авах ажиллагааны мэргэшилтэй ажилтан бэлтгэх сургалтад 05 дугаар сарын 08, 09, 12-ны өдрүүдэд хамрагдаж 05 дугаар сарын 20-ны өдрийн 2025/2358 дугаар бүхий А3 сертификат эзэмших эрхийг авлаа.	05-05	
3.	Арга хэмжээ 3. Төрийн албан хаагчдад зориулсан Монгол бичгийн цахим сургалтад хамрагдах	Сертификатын огноо, дугаар	0	1	Монгол бичгийн анхан шатны цахим сургалтад хамрагдаж 04 дүгээр сарын 02-ны өдрийн ixixxybnaw дугаарын үнэмлэх авсан.	04-04	

ТАЙЛАН ГАРГАСАН:

ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН БИЕЛЭЛТ
ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

.....


Г.ГЭРЭЛТУЯА

2025.06.09